

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гэлийн хувь
Стратеги төлөвлөгөөний зорилго: Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх замаар хүний хөгжлийн индекс 2019 онд 0.689 байгааг 2024 онд 0.719 хүргэнэ.							
Нэг. Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
1.1	Тогтвортой, хариуцлагатай, ил тод төрийн албыг төлөвшүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	-	үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	85	88	dundgovi.gov.mn, shilendans.gov.mn, tusuv-oron nutag.mn зэрэг сайтууд, ил тод байдлын мэдээллийн самбарт үйл ажиллагааны болон төсвийн мэдээ мэдээллийг тухай бүр мэдээлж, ил тод байдлыг хангаж ажиллалаа.	90
1.1.1	Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэх, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих	400,0	Хууль тогтоомж сурталчилсан тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	0	Сургалт 2 Албан хаагчид 15	Төрийн албаны тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмын хэрэгжилтийг хангаж харъяа төсвийн байгууллагын дарга, эрхлэгч, төрийн захиргааны албан хаагчдыг зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллалаа. ЗГ-ын 2019 оны 206-р тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын талаар сургалт 12 албан хаагчид сургалт зохион байгуулж, тайлан мэдээ гаргахад анхаарч ажиллах талаар чиглэл өгсөн. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтнууд болон төрийн захиргааны албан хаагчдын дунд “Төрийн албан хаагчийн манлайлал” уулзалт, ярилцлагыг зохион байгуулж Рояль ОУИС-ын төрийн удирдлагын хөтөлбөрийн удирдагч, доктор Б.Байгалмаа лекц зохион байгуулж, ЕБС-ийн	90

						захирал, МУГБагш Д.Октябрь “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага” сэдвээр сургалт зохион байгуулж 31 албан хаагч хамрагдлаа.	
1.1.2	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217, 218 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Засаг даргын Тамгын газрын нэгжийн дарга, төрийн захиргааны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	Гүйцэтгэлийн хувь	5	5	Санхүүгийн алба, төрийн сангийн мэргэжилтэн, ХААТ-ийн мал аж ахуйн менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, байгаль орчны мэргэжилтний 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, жилийн эцсээр дүгнэсэн.	90
1.1.3	Байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах хүрээнд иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэнэ.	ОНТ	Судалгаа 1 удаа, хамрагдах иргэд тоо-100	2019 оны судалгааны дүнгийн үзүүлэлт		Хийгдээгүй.	0
1.1.4	Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	-	ТАХ болон шинэчлэн гаргасан журмыг хэрэгжүүлж ажилласан ажлын тоо	1	3	Тус байгууллагад төрийн захиргааны 6 сул орон тооны захиалгыг ТАСЗ-д хүргүүлсэн. Энэ онд төрийн албаны ерөнхий шалгалт 2 удаа, тусгай шалгалт 1 удаа зарлагдсан. Санхүүгийн албаны даргын сул орон тоон дээр Боловсролын нягтлан бодогч төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгч тэнцэн 1 орон тоо нөхөгдөж томилгооны зөрчилгүй болсон. Сонгон шалгаруулалт 100% цахимаар явагдаж байна.	90
1.1.5	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна	150,0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	87,1	90	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 арга хэмжээний хүрээнд боловсруулж зохион байгуулж 88%-тай хэрэгжсэн байна.	90
1.1.6	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, урьдчилсан мэдүүлгийг гаргах	-	Хамрагдах албан тушаалтны тоо	100%	100%	Энэ онд ХАСУМ-9, ХАСХОМ 11-ийг АТГ-т хүргүүлэн хянуулсан. АТГ-ын дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох шийдвэрийг гаргаж томилогдсоноос хойш 30 хоногт	90

						багтаан ХАСХОМ-ыг гаргуулж цахимд бүртгэн баталгааны маягтаар баталгаажуулсан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 3 мэдэгдэл гаргаж ЭБАТ цэсэнд бүртгэсэн.	
1.1.7	ЗДТГ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллана.	ОНТ	Мэдээ мэдээлэл өгсөн тоо	1	4	2021 оны ЗДТГ-аас зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Дундговийн амьдрал” сонинд хэвлүүлэхээр бэлтгэж байна.	50
1.2	Төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулж, төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хүрээг нэмэгдүүлж, төрийн албаны мэргэшсэн чадварлаг, тогтвортой байх нөхцлийг бүрдүүлнэ.	ОНТ	Тухайн байгууллагад 3-аас дээш жил ажиллаж байгаа ТАХ-ийн дундаж хувь	60	70	ТАХ-ын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталсан. Төлөвлөгөөг 9 заалттайгаар батлуулж 81%-тай хэрэгжүүлсэн байна. ЗДТГ-ын 17 албан хаагчийн 12 буюу 70,5% нь байгууллагадаа 3 ба түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна.	90
			Сургалтанд хамрагдсан ТАХ-ын тоо	15	15	ЗДТГ-аас 68 удаагийн богино хугацааны /цахим, танхим/ сургалтанд 16 албан хаагчийг хамруулсан. Дотоод сургалтын төлөвлөгөөг	
1.2.1	Сумын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	ОНТ	Хэрэгжилтийн хувь	0	1	Аймгийн ИТХ-ын 2021 оны 06-р тогтоолоор батлагдсан “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс өгсөн чиглэлийн дагуу “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын төлөвлөгөөг 2 чиглэл 7 заалттайгаар батлан хэрэгжилтийг тооцоход 90,3%-тай хэрэгжсэн байна. Албан хаагчдын 12 буюу 70,5% нь 3 ба түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна.	90
1.2.2	ТАХ-ыг удирдлагын академи, болон дотоодын сургалтанд хамруулах	50,0	Сургалтанд хамрагдсан ТАХ-ын эзлэх хувь	1	3	Удирдлагын академиас зохион байгуулсан Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн талаарх сургалтанд ЗДТГ-ын дарга хамрагдаж гэрчилгээ авсан. Төрийн албан анх орсон албан хаагчдын чиглүүлэх болон мэргэшүүлэх дунд хугацааны сургалтанд хамрагдах 4 албан хаагчдын судалгааг АЗДТГ-т хүргүүлсэн.	90
1.2.3	Төрийн захиргааны албан хаагч болон төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнуудын	-	Нөхөгдсөн сул орон тоо	2	4	Төрийн үйлчилгээний 1 удирдах албан тушаалтан, төрийн захиргааны 6 сул орон тооны захиалга ТАСЗ-д хүргүүлсэн. Төрийн	90

	сул орон тоог нөхөх хүсэлтийг ТАСЗ-д уламжлах					албаны ерөнхий шалгалт 2 удаа, тусгай шалгалт 1 удаа зарлагдсан.	
1.2.4	Оюутан суралцагчдын судалгааг нарийвчлан гаргах	-	Судалгаа	1	1	Их дээд сургууль, коллежид сурдаг 49 оюутнуудын судалгааг шинэчлэн гаргасан. Оюутнуудын 20% эдийн засаг, 12% нь хууль, эрх зүй, 18,3% нь эрүүл мэнд, 10% нь боловсрол, 37% нь хөдөө аж ахуй, уул уурхай болон бусад мэргэжлийн чиглэлээр суралцаж байна. Аймгийн ИТХ-ын 2021 оны 06-р тогтоолоор батлагдсан “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын төлөвлөгөөг 2 чиглэл 7 заалттайгаар батлан хэрэгжилтийг тооцоход 90,3%-тай хэрэгжсэн байна.	90
1.2.5	Төрийн албан хаагчдыг төлөвлөгөөт болон бусад байгууллагаас зохион байгуулж буй сургалтад хамруулна.	ОНТ	Сургалтанд хамрагдалтын хувь	80%	85%	ЗДТГ-аас 68 удаагийн богино хугацааны /цахим, танхим/ сургалтанд 16 албан хаагчийг хамруулсан. Боловсролын зэрэг ахиулах сургалтанд 1 албан хаагч суралцаж төгссөн байна.	90
1.2.6	Төрийн албан хаагчдыг шинэ мэдлэг мэдээллээр тасралтгүй хангах “Мэдээллийн цаг”, шинээр томилогдсон албан хаагчдад ажлын байранд дахь сургалтыг зохион байгуулж, мэргэшүүлэх, дадлагажуулахад дэмжлэг үзүүлэх	-	Сургалт мэдээлэлд хамрагдах албан хаагчдын тоо 15	80%	85%	Төрийн албан хаагчдад эрх зүйн хөтөч багаас танхимаар болон цахимаар 30 төрлийн хууль тогтоомжоор 14 удаа сургалт хийж давхардсан тоогоор 265 албан хаагч хамрагдсан.	90
1.3	Төсөв санхүүгийн үйл ажиллагааг удирдан, төсвийн ил тод байдлыг хангана.	ОНТ	Шилэн дансны мэдээллийн тоо	-	900	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагууд болон Эмийн эргэлтийн сангийн нийт 1067 мэдээллийг шилэн дансны shilendans.gov.mn сайтад мэдээлэхээс 139 мэдээлэл мэдээлэх хугацаа болоогүй байна. 928 мэдээллийг байршуулсан.	70
1.3.1	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан санхүү, төрийн сангийн үйл ажиллагааг иргэдэд мэдээлэх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагуудын	-	Шилэн дансны хэрэгжилтийн хувь			Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагууд үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг мэдээллийн самбарт байршуулсан. Нийт 928 мэдээлэл байршуулж нийтэд мэдээлснээс 699 мэдээллийг тайлант	70

	санхүүгийн тайлан, мэдээг олон нийтэд ил тодоор мэдээлэх					хугацаанд, 229 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн.	
1.3.2	Байгууллагын орон сууцны түрээсийн гэрээний биелэлтэнд хяналт таьвж, түрээсийн төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хяналт тавих	-	Орлого төвлөрүүлэх хувь	30	30	ЗДТГ-ын ажилчдын орон сууцны түрээсийн төлбөрт нийт 1,126,000 төгрөг төвлөрүүлснээс ОНӨГ-ын түрээсийн орлого дансанд нийт түрээсийн төлбөрийн 30% буюу 337,800 төгрөгийг бүрэн шилжүүлж төсөвт 788,200 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.	90
1.3.3	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж өр авлага үүсгэхгүй ажиллах	-	Төсвийн зарцуулалтын өр авлагын хэмжээ	100	100	Тухайн жилд 352,433,400 төгрөгийн төсөв батлагдан ирсэн. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсч болзошгүй зардлыг тухай бүр төсвийн зохицуулалт хийлгэн өр авлага үүсгэлгүй ажилласан.	90
1.3.4	Байгууллагын өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг хагас, бүтэн жилээр явуулж, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр байгууллагын хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулна.	-	100% хамруулсан байна.	2	2	Байгууллагын хагас жилийн эд хөрөнгийн тооллогын ажлыг 2021 оны 7 сард багтаан нүд үзэн тоолж актлах хөрөнгийг зурагжуулан байгууллагын өмч хамгаалах зөвлөлд хүргүүлсэн. Давхар бүртгэгдсэн 1-р багийн ахмадын байрны засварыг хасаж бүртгэх гэсэн саналыг оруулсан. - Машин тоног төхөөрөмжөөс 5,543,910 төгрөгний эд хөрөнгийг - Аж ахуйн материалаас 24,000 төгрөгний эд хөрөнгийг - Программ хангамжаас 425,000 төгрөгний эд хөрөнгийг - Тусгай зориулалттай материалаас 2,155,000 төгрөгний эд хөрөнгийг - Тавилга эд хогшлоос 959,000 төгрөгний эд хөрөнгийг - Авто тээврийн хэрэгслээс 12,465,230 төгрөгний эд хөрөнгө буюу нийт 21,572,140 төгрөгний эд хөрөнгийг тус тус актлах саналыг сумын өмч хамгаалах зөвлөлд хүргүүлэн ажилласан.	90
1.3.5	Хэрэглэгчдийг статистикийн мэдээллээр хангах	-	Гаргасан статистик мэдээллийн тоо	0	3	Статистикийн хэлтсээс сар бүр гаргадаг нийгэм, эдийн засгийн тойм мэдээг сумын иргэдийн хамгийх их хандалт хийдаг 2 цахим группт бүр байршуулсан. Аймгийн ХХААГ-т ургацын болон хүнс, өргөн хэрэглээний	90

						барааны үнийн мэдээ судалгааг 32 удаа гаргаж өгсөн байна.	
1.3.6	Тооллого, судалгаа явуулах	500,0	Тоо	2	2	25 ААНБ 25, 8 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг тооллогод 100% хамруулсан байна. 2021 оны мал болон тэжээвэр амьтдын тооллогыг хугацаанд зохион байгуулсан.	90
1.4	Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг 85%-д хүргэнэ.	-	Хэрэгжилтийн хувь		85	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулж, цэргийн насны залуучуудын боловсрол, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулж эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. 2020 оны 1-р ээлжийн цэргүүдийг хүлээн авч үзлэг шинжилгээнд хамруулан ар гэрт нь хүлээлгэн өгсөн. Цэргийн дүйцүүлэх албанд хамрагдах цэргийн насны залуучуудын мэдээллийг Цэргийн штабт хүргүүлсэн.	90
1.4.1	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэд, байгууллага аж ахуйн нэгжид сурталчилж, хяналт тавина.	ОНТ	Хууль тогтоомж сурталчилсан тоо	2	2	Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулж, цэргийн насны залуучуудын боловсрол, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулж эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. 2020 оны 1-р ээлжийн цэргүүдийг хүлээн авч үзлэг шинжилгээнд хамруулан ар гэрт нь хүлээлгэн өгсөн.	70
1.4.2	Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулна.	ОНТ	Үйл ажиллагааны тоо	1	2	Цэргийн тоо бүртгэлийн үеэр цэрэг татлагын товчоогоор орох 18-26 насны 25 залуучуудад цэргийн албаны тухай хуулиар бэлтгэсэн гарын авлагыг тарааж сургалт сурталчилгааг хийсэн.	70
1.4.3	Цэргийн тоо бүртгэл, цэрэг татлагын үйл ажиллагааг зохион байгуулна.	ОНТ	Хяналтын тооны хувь	2	2	Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах комиссыг сумын Засаг даргын 2021 оны А/02 дугаар захирамжаар байгуулан зохион явууллаа. Улсын хэмжээнд Ковид-19 цар тахлын өвчлөл гарсантай холбогдуулан цэргийн шинэчилсэн тоо бүртгэл явуулах зар мэдээллийг цахимаар мэдээлж багийн дарга нараар цэргийн үүрэгтнүүдэд утсаар мэдээлэл хүргэж ажилласан. Сумын хэмжээнд шинэчилсэн тоо бүртгэлд ирж хамрагдвал зохих 18-50 насны 264 цэргийн үүрэгтнээс	90

						цэргийн шинэчилсэн бүртгэлд өөрийн биеэр ирж бүртгүүлсэн 251 үүрэгтэн, гадаадад ажиллаж амьдарч байгаа 8, хаягандаа байхгүй 5 цэргийн үүрэгтэн бүртгэлд хамрагдах боломжгүй байлаа. Бүртгэлийн үеэр цэрэг татлагын товчоогоор орох 18-26 насны залуучуудад цэргийн албаны тухай хуулиар гарын авлага боловсруулан 25 үүрэгтэнд олгож сургалт сурталчилгааг хийсэн. Ковид-19 халдварын улмаас 2021 оны 1-р ээлжийн цэрэг татлага зохион байгуулагдаагүй.	
1.4.4	Цэргийн бэлтгэл сургалтанд хамрагдана.	ОНТ	Хамрагдалтын хувь	0	1	Ковид-19 халдварын улмаас зохион байгуулагдаагүй.	ҮБ-гүй
1.4.5	Цэргийн жинхэнэ албанд татагдагчдын өвчлөлийн судалгааг гаргаж, эрүүлжүүлэх арга хэмжээг ЭМТ, багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулна. Цэргийн насны залуучуудын боловсролын дээшлүүлэх ажлыг НТБ-ын багштай хамтран зохион байгуулна.	ОНТ	Эрүүлжүүлэлтийн хувь Боловсролыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын тоо	80	85	Цэрэг татлагаас эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн залуучуудыг эрүүлжүүлэх төлөвлөгөөг гаргаж ажилласан. Төлөвлөгөөний дагуу 12 үүрэгтэнг багийн эмч нар хяналтанд авч улирал бүр үзлэгт хамруулан шаардлагатай эмчилгээг хийж, зөвөлгөөг өгч ажилласан. 18-26 буюу цэргийн насны 29 залуучууд бүртгэлтэй байна. Эдгээрийн 17% нь дээд, 50% нь бүрэн дунд, 38% нь суурь боловсролтой байна. Цахимаар 1 удаа мэдээлэл хүргэж 16 хандалт авсан байна.	70
1.4.6	Дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг жил бүр тодотгож, баталгаажуулах, даалгаваржуулах дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний бэлэн байдлыг ханган ажиллана.	ОНТ	-	1	1	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн дагуу орон нутгийн хамгаалалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн Цэргийн штабт шаардлагатай судалгаа мэдээллийг хүргүүлсэн. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг тодотгож батлуулсан.	90
1.5	Гамшигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг ханган гамшгаас үүдэлтэй хохирлын хэмжээ бууруулна.	ОНТ	Хохирлын хэмжээний бууралт	-	-	Коронавируст цар тахал болон байгалийн гамшигтай тэмцэх чиглэлээр төрийн байгууллагуудын гамшгаас хамгаалах хуулинд заасан үүргийг хэрэгжүүлж төсвийн 1% болох 13,414,447 төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж оношлуур, хувцас хамгаалах хэрэгсэл, шатахуун, сургалт сурталчилгаа, постны хоол хүнс, тохижилт, тусгаарлах байрны бэлэн байдлыг хангуулах зардалд нийт 16,505,380 төгрөгийг зарцуулсан байна. Мөн ЗДТГ-ын хөрөнгөөр 5 сая төгрөгний гамшгаас	90

						хамгаалах дуут дохио, 4 сая төгрөгөөр дрон авч гамшгаас хамгаалах, тэмцэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлээ.	
1.5.1	Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх дадлага, сургууль, үзлэгт хамрагдах	ОНТ	Дадлага, сургуульд хамрагдсан хувь	-	1	Ковид-19 халдварын улмаас зохион байгуулагдаагүй.	ҮБ-гүй
1.5.2	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг жил бүр тодотгох	ОНТ	Тоо	1	1	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгосон.	90
1.5.3	Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд гамшигтай тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулах, түүнд идэвхтэй оролцох, оролцуулах	ОНТ	Сургалтын тоо	-	-	Ковид-19 халдварт цар тахал, байгалийн гамшигт үзэгдэл болсонтой холбогдуулан сумын онцгой комисс, мэргэжлийн анги, шуурхай, штабын бүрэлдэхүүнд тодотгол хийж эргүүл постонд ажиллах, халдвар хамгааллын дэглэм баримтлах, иргэдийг соён гэгээрүүлэх, гамшигт өртсөн айл өрх, малчдад туслах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулах бүрт заавар зөвлөгөөгөөр хангаж ажилласан.	90
1.6	Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг бууруулна.	-	нийтийн цэвэрлэгээ зохион байгуулсан тоо	2	2	Иргэдийн цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Цэмцгэр Цагаандэлгэр-2021” аяны хүрээнд 2021 оны 5, 11-р сад бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа хийлээ. Нийтийн их цэвэрлэгээнд 5 авто машин, 40 гаруй албан хаагчид, 65 иргэд оролцож 18 тн хог хаягдыг ачиж цэвэрлэсэн.	90
1.6.1	Гэр хороолол, үйлчилгээний бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонгийн тоог нэмэгдүүлэх	ХХО	Нэмэгдүүлсэн тоо	10	35	2021 оны 6 сард төвийн айл өрхийн нүхэн жорлонгийн талаар судалгаа гаргасан. Үүний дагуу айл өрхүүдийг урин дулааны цагт нүхэн жорлонгоо шинэчлэх, засан сайжруулах талаар зөвлөгөө, чиглэл өгч ажилласнаар 15 айл өрх шаардлага хангасан 00-той болсон.	90
1.6.2	Төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж булшлах	ОНТ	Талбайн хэмжээ		50	Сумын төв хогийн цэгийн хог хаягдлыг шууж, булшлах талбайн газрын дүгнэлт гаргасан. Хогийн цэгийн хог хаягдлыг булшлах, устгах ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөө, төсөв тооцоог гарган УОК-оос томилогдон ирсэн ажлын хэсэгт гарган өгч нөхцөл байдлыг танилцуулсан. Аймгийн Засаг даргаас 10 сая, Сумын Засаг даргын нөөцөөс 4,4 сая, гамшгаас хамгаалах зардлаас 500,0 төгрөгийг бүрдүүлж нийт 14,9 сая төгрөгөөр төв хогийн	30

						цэгийг шууж, булшлах ажлыг 2022 онд хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан.	
1.6.3	Айл өрх, ААНБ-ийн хог ачилтыг сард 2 удаа зохион байгуулж хяналт тавих	ОНТ	Тоо	-	24	Хог тээврийн машинаар сард 2 удаа айл өрх, албан газруудын хогийг ачиж зөөсөн.	90
1.6.4	Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах	ОНТ	Тоо	2	2	Иргэдийн цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Цэмцгэр Цагаандэлгэр” аяны хүрээнд 2021 оны 5, 11-р сад бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа хийгдлээ. Нийтийн их цэвэрлэгээнд 2 авто машин, 40 гаруй албан хаагчид оролцож 18 тн хог хаягдыг ачиж цэвэрлэсэн.	90
1.7	Усны бохирдлоос сэргийлнэ.	ОНТ	Хувь	-	90	Сумын төвийн худгаас ундны усны шинжилгээг 2 удаа хийсэн. Ундны усны бохирдлоос сэргийлж Хараатын сүүжийн худгийн доторх хог хаягдлыг 2 удаа цэвэрлэж, хашаа хайсыг будаж сэргээж, хашааны эвдрэлийг зассан	90
1.7.1	Сумын төвийн ундны усанд улирал бүр шинжилгээ хийлгэх	100,0	Тоо	2	4	Ундны усны шинжилгээг 2 удаа хийсэн.	90
1.7.2	Ундны усны газрын хамгаалалтын бүсийг сайжруулах	20,0	Тоо	1	2	Ундны усны бохирдлоос сэргийлж Хараатын сүүжийн худгийн доторх хог хаягдлыг 2 удаа цэвэрлэж, хашаа хайсыг будаж сэргээж, хашааны эвдрэлийг зассан.	70
1.7.3	Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах	200,0	Тоо	1	1	Аймгийн Засаг дарга, БОАЖСайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор сумын нутаг дэвсгэрт байрлах 7 булаг, шандны эх дээр хамгаалалтын бүс тогтоосон тухай тэмдгийг байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	90
1.8	Ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	ОНТ	Ургалтын хувь Хэмжээ			Хавар, намрын 2 удаагийн тариалалтаар 1,5 га талбайд 1200ш мод тарьсан.	90
1.8.1	Цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	2,0	Нэмэгдүүлсэн талбайн га	1	2	Цэцэрлэгт хүрээлэн дэх ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр намрын тариалалтаар 0,5 га талбайд 400 мод тарьсан.	90
1.8.2	Иргэн, ААНБ-ыг өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод тарих ажлыг зохион байгуулах	ХХО	Тоо	5	5	3 иргэн, 1 байгууллагыг өөрийн эзэмшлийн талбайд мод тарих ажлыг зохион байгуулсан.	50
1.9	Татварын бааз суурийг нэмэгдүүлж, татварын	-	Хувь	100	100	Татварын орлогын баазыг өмнөх оноос 44 сая төгрөгөөр нэмэгдүүлж ажилласан.	90

	тайлагналт, хураалтын үйл ажиллагааны цахимжуулалтыг сайжруулна.						
1.9.1	Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлэх	-	Биелэлтийн хувь	100	100	Орон нутгийн төсөв 88380.0 төгрөг төвлөрүүлэхээс малын тоо толгойн албан татварыг 50 хувь хөнгөлж нийт 58380,0 орлого оруулахаас 81212,0 төгрөгийн орлого төвлөрч биелэлт 139%, Аймгийн төвлөрсөн орлого 74500,0 төгрөг төвлөрөхөөс 65356,0 төгрөг төвлөрч 87,7%, Улсын төвлөрсөн орлого 2400.0 төгрөг төвлөрөхөөс 2940.0 төгрөг төвлөрч 122% тай байна.	90
1.9.2	Татварын тайлан буюу цахимаар ирүүлбэл зохих тайлангийн хувийг нэмэгдүүлэх	-	Цахимаар ирүүлсэн тайлангийн хувь	100	100	ААНэгж, албан байгууллага иргэдийн тайлан 2020 оноос эхлэн 100 хувь цахимжсан.	90
1.9.3	Татвар төлөгчийн төрлийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	-	Төрлийн тоо	0	1	Татвар төлөгчийн төрөл 1-ээр нэмэгдсэн	90
1.10	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй явуулна.	-				Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй зарлан мэдээлж танилцуулсан. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр зарлагдсан 3 ажлаас 2 ажлыг орон нутгийн 2 бүлэг хийж гүйцэтгэсэн. Итгэл дүүрэн бүлэг багш нарын байрны засварын ажлыг 9831.000, Түмэн залаат бүлэг 2-р багийн төв барих ажлыг 19000.000 төгрөгөөр хийсэн.	90
1.10.1	Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон фейж хуудас, мэдээллийн самбараар тухай бүр мэдээлэх	-	Үр дүнг нийтэлсэн тоо	0	8	Гэрээ шууд байгуулах аргаар 3 тендер зарласан. Тендерийн урилгыг цахим хуудсанд байршуулж 3-аас дээш компанид урилга хүргүүлэн тухай бүр мэдээлсэн. Мөн мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан	90
1.10.2	Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах, сургалтанд хамруулах	-	Сургалтын тоо АЗ-тай иргэдийн тоо	0	3	АЗ сертификатай иргэдийн нөөц бүрдүүлэх 1 удаагийн сургалт зохион байгуулагдсан. Үүнд 4 иргэн хамрагдаж 3 нь тэнцсэн.	70
Хоёр. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
2.1	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль	ОНТ	Хамрагдсан иргэдийн хувь	10	10	Хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн хөтөч багаас 2021 онд байгууллага, албан хаагчидтай	90

	эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж үйлчилгээг иргэдийн 10-аас доошгүй хувьд хүргэнэ.					хамтран судлан сурталчлах хууль эрх зүйн актын нэгдсэн төлөвлөгөөг батлуулж танхимаар 3, цахимаар 17 удаагийн хууль, эрх зүйн сургалт мэдээллийг төрийн байгууллагын нийт 75 албан хаагчдад хүргэсэн. Иргэд олон нийтэд цахим сүлжээгээр хууль эрх зүйн мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. Хараат багийн хөдөөгийн 17 малчин иргэдэд эрх зүйн богцыг аялуулсан байна. 4 багийн иргэдийн нийтийн хурлын үеэр 13 төрлийн гарын авлага боловруулж 321 иргэдэд түгээсэн байна.	
2.1.1	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллана.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	85	90	Бүх нийтийн эрх зүйн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж 88%-тай хэрэгжүүлсэн байна.	70
2.1.2	Иргэд, олон нийтэд чиглэсэн хууль зүйн тусламж үйлчилгээ, сургалт сурталчилгааг зохион байгуулах	ОНТ	Сургалтын тоо	2	3	Танхимаар 3, цахимаар 17 удаагийн хууль, эрх зүйн сургалт мэдээллийг төрийн байгууллагын нийт 75 албан хаагчдад хүргэсэн. Иргэд олон нийтэд цахим сүлжээгээр хууль эрх зүйн мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. Хараат багийн хөдөөгийн 17 малчин иргэдэд эрх зүйн богцыг аялуулсан байна. 4 багийн иргэдийн нийтийн хурлын үеэр 13 төрлийн гарын авлага боловруулж 321 иргэдэд түгээсэн байна.	70
2.1.3	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх	ОНТ	Хамрагдсан иргэдийн тоо	-	4	Иргэний нийгмийн болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд хүний эрхийг хамгаалах, хангах хүрээнд 345 иргэнд нотариатын /итгэмжлэл, хуулбар, гэрээ, гарын үсгийн баталагаа/ үйлчилгээ болон бусад чиглэлийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлсэн	70
2.1.4	Иргэний танхимын үйл ажиллагааг тогтмолжуулж, үйлчилгээний төрөл, чанарт анхаарч ИТХ-тай хамтран ажиллах	ОНТ	Үйл ажиллагааны тоо	2	4	Иргэний танхимд ЗДТГ-аас 2 сая төгрөгийн урсгал засварыг хийж, халаалтын системийг сайжруулж ажилласан. ИТХ-тай хамтарч иргэний танхимд ээлжит хуралдааны зохион байгуулалт болон аж ахуйн чиглэлээр хамтран ажиллаж байна. Иргэдийг мэдээлээр хангахаар Дундговийн амьдрал сонинг тогтмол захиалж аймаг болон сум орон нутгийн мэдээллээр хангаж ажиллалаа.	90

2.1.5	“Эрх зүйн хөтөч” багийн үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	ОНТ	Хэрэгжилтийн хувь	80	90	АЗДТГ-аас 2021.05.11-ний өдөр сумдын эрх зүйн хөтөч нарт зохион байгуулсан албан бус сургалтанд 4 эрх зүйн хөтчийг хамруулж хөтчүүдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. Эрх зүйн хөтөч багаас төрийн байгууллагын нийт 75 албан хаагчдад 20 /танхим болон цахим/ удаагийн сургалтаар хууль эрх зүйн мэдээ мэдээллийг хүргэсэн.	70
2.1.6	Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын санг бүрдүүлэх, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж цахим санг үүсгэнэ.	ОНТ	Актын тоо Цахим сан оруулсан тоо	0	1	Сумын ИТХ-аар нийт захиргааны хэм хэмжээ тогтоосон акт 4 байна. Үүнээс Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоосон 2020 оны 12 дугаар тогтоолыг ХЗДХЯ-нд хянуулж бүртгэл мэдээллийн санд оруулсан. Албан хэрэг хөтлөлтийн программд төсөвт байгууллагын 2009-2020 оны 120 эрх зүйн актыг шивж, скайнердаж, CD дээр буулгаж цахимжуулаад байна.	90
2.2	Төрийн байгууллагын үйл ажиллагааг хүртээмжтэй, нээлттэй болгож, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэдээ дээдэлсэн үйлчилгээг эрхэмлэнэ.	ОНТ	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо			Төрөөс иргэдийн авдаг төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэхээр төрийн үйлчилгээг цахимжуулах, онлайн хэлбэрт шилжүүлэх ажлыг шат дараатай хийж байна. Ерр, e-mongolia, Хур систем зэрэг төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан иргэд орон зай, цаг хугацаанаас үл хамааран төрийн үйлчилгээг цахим технологи ашиглан авч байна. Ерр төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, үйлчилгээг цахимаар үзүүлэх ажлын эхлэл тавигдсан. e-mongolia системд 23 байгууллагын 181 үйлчилгээг нэвтрүүлж гар утаснаас дээрх үйлчилгээг авч байна. Хур системээс 54 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна.	90
2.2.1	Цахимаар үйлчлэх боломжтой төрийн үйлчилгээг сурталчилж, иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэнэ.	ОНТ	Цахим үйлчилгээний тоо	54	54	Хур системээр нийт 24 иргэнд 6 төрлийн лавлагааг олгосон байна. Архивын цахим сангаас 17 иргэнд лавлагаа олгосон байна. МЭНСистем бүрэн ашиглаж эхэлсэн ба мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээг тухай бүрт нь цахимаар хянан баталгаажуулж байна. Газрын харилцааны 17 төрлийн үйлчилгээ бүрэн цахимжиж эхэлсэн.	90
2.2.2	Иргэддээ ил тод, нээлттэй, хүнд сурталгүй шуурхай, чанартай,	ОНТ	Өдөрлөг, уулзалтын тоо	-	1	4 багийн иргэдийн нийтийн хуралд сумын удирдлагууд, ЗДТГ-ын албан хаагчид,	70

	иргэндээ чиглэсэн үйлчилгээг нэвтрүүлж "Иргэдтэй уулзах уулзалт, өдөрлөгийг зохион байгуулан иргэдээ сонсоно.					байгууллагын дарга нар оролцож мэдээ мэдээлэл хүргэж ажилласан. Аймгийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр захирамжаар баталсан "Аймаг сумдын Засаг дарга, засаг даргын орлогч нар 7 хоногийн Бямба гараг бүр иргэдийг хүлээн авч уулзах уулзалтын журам"-ыг цахим орчинд байшгуулж иргэдэд сурталчилсан.	
2.2.3	Улирал бүр ЗДТГ-аас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар тайланг хэвлэмэл байдлаар гарган иргэдэд боломжит хувилбараар хүргэж төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах	ОНТ	Тоо	-	1	4 багийн иргэдийн нийтийн хуралд ЗДТГ-ын 2021 оны үйл ажиллагааны товч тайланг танилцуулсан. ЗДТГ-аас зохион байгуулсан үйл ажиллагааны товч мэдээллийг цахим орчинд постер хэлбэрээр байршуулах, "Дундговийн амьдрал" сонинд хэвлүүлэхээр бэлтгэж байна. Сумын санхүүгийн албаны үйл ажиллагааны тайланг гарын авлага боршур хэлбэрээр бэлтгэн 151 иргэнд тарааж өгсөн.	70
2.2.4	Цаг үеийн онцгой нөхцөл байдлын үед төрийн албан хаагчдыг цахимаар ажиллах боломжийг бүрдүүлэх замаар төрийн албаны шуурхай байдлыг хангах	ОНТ	Тоо	-	-	Коронавируст Ковид-19 халдварын улмаас бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд албан хаагчдын ажлыг цагийг богиносгох, зарим албан хаагчдыг цахимаар гэрээс ажиллах шийдвэрийг 2 удаа гаргаж ажилласан. Сумын ЗДТГ-ын интернетийн хурдыг нэмэгдүүлэхээр Мобинет ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан 5 mb хурдаар интернетийн үйлчилгээ авч, интернетийн бодит хаягтай болж цахим хурлын үйл ажиллагаанд тогтмол оролцох боломж бүрдсэн. Зөөврийн интернет төхөөрөмж гэрээгээр авч албан хаагчдыг цахимаар ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.	90
2.2.5	www.dundgovi.gov.mn болон Цагаандэлгэрийн мэдээ цахим хуудсаар дамжуулан сумынхаа цаг үеийн мэдээлэл, үйл ажиллагааг иргэдэд ил тод мэдээлэх	ОНТ	Мэдээний тоо	-	48	Аймгийн сайтад 56 мэдээ мэдээлэл, сумын фейсбүүк хуудсанд 89 мэдээ мэдээллийг байршуулж 1083 иргэнд түгээсэн байна. Төрийн байгууллагуудаас зохион байгуулсан шинэлэг ажлуудын талаарх 72 мэдээ мэдээллийг Цагаандэлгэрийн мэдээ цахим хаягаар сурталчилж байна. Төрийн байгууллагууд ил тод байдлын мэдээллийн самбарт худалдан авах ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн талаарх мэдээллүүдийг тухай бүр байршуулж тогтмол шинэчилж байна.	90

2.3	Архив, албан хэрэг хөтлөлтийн шийдвэрлэлт, хяналтыг сайжруулан, сургалт зохион байгуулан архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдүүлнэ.	ОНТ	Стандарт, журмын хэрэгжилтийн хувь	90	90	Байгууллагын дотоод сургалтаар албан хаагч нарт архив, албан хэрэг хөтлөлтийн талаар цахимаар 1 удаа сургалт зохион байгуулсан.	90
2.3.1	Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтныг мэргэжлийн сургалт, семинарт хамруулж, мэргэшүүлэх	50,0	Сургалт, семинарт хамрагдсан тоо	1	2	Архивын тасгаас зохион байгуулсан танхимын, Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан цахим сургалтад тус бүр 1 удаа хамрагдсан байна.	90
2.3.2	Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт, нэгдсэн системийн ашиглалтын талаар ЗДТГ-ын албан хаагчдад сургалт зохион байгуулах	ОНТ	Сургалтын тоо	2	4	Мэдээллийн цагаар албан хаагчдад “Баримт бичгийн стандарт” сэдвээр цахимаар, байгууллагын дарга, эрхлэгч нарт “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт”-ийн талаар сургалтыг танхимаар зохион байгуулсан. Сургалтыг 2 удаа зохион байгуулсан.	90
2.3.3	Архивын баримтын тоо бүртгэлийн мэдээг үнэн зөв гаргаж, төрийн архивын баримтын 95-аас дээш хувийг цахим хэлбэрт шилжүүлж, байгууллага, ААН, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх	ОНТ	Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын тоо	90	95	Архивын баримтын тоо бүртгэлийн мэдээг аймгийн архивын тасагт оны эхэнд гаргаж явуулж байна. Албан хэрэг хөтлөлтийн программд төсөвт байгууллагын 2009-2020 оны 120 эрх зүйн актыг шивж, скайнердаж, CD дээр буулгаж цахимжуулаад байна.	90
2.3.4	Сумын ЗДТГ-ын 2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлуулах	ОНТ	Тоо	-	-	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын боловсруулж байгууллагын даргаар баталгаажуулан мөрдөж ажиллаж байна.	90
2.3.5	Байгууллагын архивт ЗДТГ-ын 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтуудад нөхөн бүрдүүлэлт хийх	ОНТ	Төрийн архивт тавигдах шаардлага үзүүлэлт хангагдсан байна.			Албан байгууллага, албан хаагч нар графикайн дагуу нийт 135 баримтыг байгууллагын архивт 100% шилжүүлсэн байна.	90
2.3.6	ЗДТГ-ын 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн хадгаламжийн нэгжүүдийг БНШК-ын хурлаар хэлэлцүүлэх	ОНТ	Тоо	1	2	Байнга хадгалах баримт, түр хадгалах баримт данс, бүртгэл, устгах хэргийн актыг байгууллагын БНШК болон Төрийн архивын БНШАЗК-ын хурлаар 2012-2019 он хүртэл хэлэлцүүлж, баталгаажуулсан байна.	90
2.3.7	Архив, албан хэргийн аяныг зохион байгуулах	ОНТ	Аяны үр дүн	-	1	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан журам, дүрмийг сурталчлан таниулах аяны ажлын төлөвлөгөөг ЗДТГ-ын даргаар батлуулан 3 төрлийн сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулж, 25	90

						албан хаагчийг хамруулж зөвлөгөө мэдээлэл өгсөн.	
2.3.8	ЗДТГ болон харьяа байгууллагуудад ирсэн, явсан албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг улирал, хагас, бүтэн жилээр гарган тайлагнаж, удирдлагыг мэдээллээр хангаж, шийдвэрлэх хугацаа дууссан, зөрчил тооцогдсон албан бичгийн мэдээг тогтмол гаргаж танилцуулах	ОНТ	Мэдээний тоо Зөрчлийн бууралт	-	100	Ер.e-mongolia.mn системд ирсэн бичиг 103, явсан бичиг 37, нийт 140 бичгийг бүртгэж албан хэрэг хөтлөлтийг цахимаар явуулж байна. Хариутай бичгийн мэдээг хөтлөж улирал бүр Тамгын газрын даргад танилцуулан ажиллаж байна.	70
2.3.9	ЗДТГ-ын харьяа төсвийн байгууллагуудын удирдлагаас гаргасан тушаалын хууль зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгөх	ОНТ	Үзлэгт бэлтгэсэн байдлаар	2	4	Төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарын эрх зүйн актыг улирал бүр хянаж, гарсан зөрчлийг зөвлөмжөөр хүргүүлж, нийт 88 эрх зүйн актыг хянасан байна.	90
2.3.10	Сумын Засаг даргын захирамж, ЗДТГ-ын тушаалын хууль зүйн үндэслэлийг хянуулах, холбогдох мэргэжилтэн, иргэд, олон нийтийн санал, зөвлөмжийг тусгах, ил тод сурталчлан хэрэгжүүлнэ.	ОНТ	Эрх зүйн актын хянуулсан тоо, Алдаа зөрчлийн бууралт	-	100	Засаг даргын А/Б захирамж 124, Тамгын газрын даргын А/Б тушаал 73, нийт 197 эрх зүйн актыг хянуулж зөвлөмжөөр илэрсэн зөрчлийг арилгаж хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан.	90
2.3.11	Нотариатын үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай чирэгдэлгүй ил тод нээлттэй хүргэн үйлчлэх	ОНТ	Тоо	-	100	Сумын ЗДТГ-ын дарга нотариатын үүргийг хавсран гүйцэтгэж гэрээ баталгаажуулах 61, итгэмжлэл 40, баримт бичгийн хуулбар 215, гарын үсгийн баталгаа 41 нотариатын үйлдэл хийсэн байна. Сумын нотариатын үйлчилгээний талаар санал гомдол гараагүй, чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилж ажилласан байна. Нотариатын үйлчилгээний хөлсийг төлбөрийн хүсэлт үүсгэн улсын тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлсэн байна.	90
2.4	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.	ОНТ				Иргэдээс ирсэн өргөдлийг хүлээн авч хяналтын карт хөтөлж удирдлагад танилцуулж холбогдох мэргэжилтэн, албан хаагчдаар шийдвэрлүүлж байна.	90
2.4.1	Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн дагуу хүлээн авах, шийдвэрлэх, хариуг хугацаанд нь хүргүүлж, мэдээг	ОНТ	Шийдвэрлэлтийн хувь Тайлангийн тоо	-	100	Сумын хэмжээнд төсөвт байгууллагад иргэдээс ирүүлсэн 164 өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авсан. Үүнд: хүсэлт-	90

	батлагдсан хуваарийн дагуу холбогдох газарт хүргүүлнэ.					29, санал-30, гомдол-14, бичгээр-34, утсаар-35, амаар биечлэн-22 ирснийг хүлээн авч шийдвэрлэлээ. ЗДТГазарт бичгээр 20 өргөдөл ирснийг хүлээн авч хяналтын карт хөтлөж, цахимд системд бүртгэж байна. Шийдвэрлэлт 100%, тайланг 2 удаа явуулсан байна.	
2.4.2	Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах нээлттэй утсыг сурталчлах	ОНТ	Сурталчлсан тоо	4	12	Иргэдээс санал, хүсэлт хүлээн авах 80648580, 75775959 нээлттэй утсыг тогтмол ажиллуулж байна. Цахимд 3 удаа сурталчилгаа байршуулсан, БИНХурлаар гарын авлага, боршур хийж 86 иргэнд хүргэсэн.	70
2.5	Төрийн албан хаагчдын ажлын үр дүн, хариуцлага тооцох системийг оновчтой хэрэгжүүлж, тэдний ажиллах таатай орчныг бүрдүүлэх, “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлнэ	ОНТ	Хэрэгжилтийн хувь	85	90	2021 онд ЗДТГ-ын 17 албан хаагч төрийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа. ЗГ-ын 2019 оны 5, 6, 7, 382 дугаар тогтоолуудаар баталсан холбогдох журмын дагуу Төрийн захиргааны 5 албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшуулал, төрийн үйлчилгээний 6 албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшуулал, сар бүр ур чадварын нэмэгдэл, буцалтгүй тусламж, хөнгөлөлт, нөхөх төлбөр зэргийг олголоо. Аймгийн ИТХ-ын 2021 оны 06-р тогтоолоор батлагдсан “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс өгсөн чиглэлийн дагуу “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын төлөвлөгөөг 2 чиглэл 7 заалттайгаар батлан хэрэгжилтийг тооцоход 90,3%-тай хэрэгжсэн байна.	90
2.5.1	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНТ	Төрийн одон медаль болон аймаг, сумын шагналаар шагнагдсан ТАХ-ын эзлэх хувь	-	2	2021 онд ЗДТГ-аас төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор 1, “Хөдөлмөрийн хүндэт” медалиар 1, “аймгийн хүндэт тэмдэг”-ээр 1, АЗД-ын “Жуух бичиг”-ээр 1 албан хаагч шагнагдсан.	90
			Бусад дэмжлэг, тусламж, урамшуулалд хамрагдсан ТАХ-ын эзлэх хувь	-	5	ЗДТГ-аас тэтгэвэрт гарсан 2 ахмад албан хаагчид 350000 төгрөг, шилжин ажиллаж буй 3 албан хаагчид 150000 төгрөг, байгууллагын 16 албан хаагчийн 25 хүүхдэд 200000 төгрөг, 5 албан хаагчид ур чадварын нэмэгдэлд 4,8 сая төгрөг, төрийн алба хаасан хугацааны	

						нэмэгдэл 7 албан хаагчид 5,2 сая төгрөг тус тус олгосон байна. 2 албан хаагчийн цалингийн шатлал ахиулж, Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэхэд анхаарч бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийг богиносгосон цагаар ажиллуулсан байна. Нийт 17 албан хаагчид 3,400,000 төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт дэмжлэг үзүүлсэн байна. Төсөвт байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу үнэн зөв бүрэн гаргаж зөрчилгүй ажилласан 3 албан хаагчид нийт мөнгөн урамшуулал олгосон. Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2 албан хаагчид нийгмийн баталгааг хангахад чиглэсэн 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.	
2.5.2	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнүүлэх, ажлын зохион байгуулж, үр дүнг харгалзан зэрэг дэв олгох, цалингийн шатлал ахиулах, шагнал урамшуулал олгох асуудлыг хууль, тогтоомж журмын дагуу шийдвэрлүүлэх	ОНТ	Тоо	1	3	Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэн 5 албан хаагчид улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.	90
2.5.3	Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагатай хамтран Засаг даргын Тамгын ажилтнуудыг жилд 1-ээс доошгүй удаа нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоонд хамруулж, архаг өвчтэй ажилтнуудыг эмчийн болон эмнэлгийн хяналтад авч рашаан сувилалд сувилуулах, эмнэлгийн тусламж дэмжлэг үзүүлэх ажлыг хамтран зохион байгуулах	ОНТ	Тоо	0	1	Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан байгууллагын 21 албан хаагчийг нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоонд хамруулж, архаг өвчтэй ажилтнуудыг эмчийн болон эмнэлгийн хяналтад авсан.	90
2.5.4	Төрийн албан хаагчдын баримтлах ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн	ОНТ	ТАХ-ын сахилга хариуцлагын	-	-	ЗДТГ-аас 17 төрийн албан хаагчидтай 2021.01.14-нд ёс зүй, хариуцлагын гэрээ байгуулсан. Байгууллагын албан хаагчдын	90

	зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллана.		зөрчлийн бууралт			дунд “Төрийн албан хаагчийн манлайлал” уулзалт, ярилцлагыг зохион байгуулж МУГБагш Д.Октябрь “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага” сэдвээр сургалт зохион байгуулж 21 албан хаагч хамрагдлаа.	
2.5.6	Төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож байх	ОНТ	Зөрчил бүрт арга хэмжээ тооцсон байдал	-	-	1 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан.	90
2.6	Уул уурхай улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгэнэ.	ОНТ				Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар тооллого, судалгаагаар илрээгүй.	90
2.6.1	Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийлгэх	-	Га			Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газар тооллого, судалгаагаар илрээгүй.	90
2.6.2	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 1-ээс доошгүй удаа холбогдох байгууллагуудын хяналт, шалгалт явуулж хяналт тавих	-	Тоо			Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 2 газар байгаа боловч үйл ажиллагаа явуулаагүй болно.	90
2.7	Газрын маргааны асуудлыг шийдвэрлэнэ.		Шийдвэрлэлтийн хувь		80	Сум хоорондын хилийн цэсийн дотор олгогдсон Говь-угтаал сумын 8, Баянжаргалан сумын 1 иргэний өвөлжөө, хаваржааны газрыг олгуулах хүсэлтийг сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар санал ирснийг ИТХ-д өргөн барьж байна. Мөн Цагаандэлгэр сумын 1 иргэний өвөлжөө нь Говь-угтаал сумын нутагт орсон тул тухайн сумаас тус бууцыг эзэмшүүлэхээр хүсэлтийг хүргүүлсэн. Газар эзэмших эрх шилжүүлэх 9, эзэмших эрхийн хугацаа сунгах 5, шинээр газар эзэмших 10, эзэмших эрхийг хүчингүй болгох 2, эзэмших эрхийг өвлөж авах 2 өргөдлийг тус тус шийдвэрлэсэн. Газрын кадастрын мэдээллийн санд ороогүй Засаг даргын захирамж гарсан 10 иргэний өргөдлийг хүлээн авч улсын бүртгэлийн Е дугаар авахуулан мэдээллийн санд оруулсан.	90

2.7.1	Өвөлжөө, хаваржааны газрын маргаантай газрыг сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж шийдвэрлэх	-	Маргаантай газрыг ГЗБ-ын төлөвлөгөөнд тусгуулсан тоо	-	3	4 багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэгдэн батлагдсан 12 иргэний өвөлжөө хаваржааны зориулалтаар олгох 13 газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.	90
2.7.2	Сум хоорондын хил дамнан олгогдсон өвөлжөө, хаваржааны газрын маргааныг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах	-	Шийдвэрлэлтийн хувь	-	50	Хилий цэсийн гадна Говь-угтаал сумын нутагт Хөвийн хар гэх бууц нь орсон 1 иргэний хүсэлт, материалыг Говь-угтаал сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хүргүүлсэн.	90
2.8	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоог дэмжиж, бэлчээр хамгаалах ажлыг зохион байгуулна.	37 сая	Зохион байгуулсан ажлын тоо	1	3	Хоршоог дэмжих чиглэлээр “Малын цахим бүртгэлжүүлэлт, эзмэгжүүлэлт”-ийн аяны ажлыг Хүнс хөдөө аж ахуйн яам, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран зохион байгуулж малчид иргэдэд Монголын арьс шир, ноос ноолуурын холбоо, Хүнс хөдөө аж ахуйн газраас 1 удаа сургалт явуулсан. Бэлчээр хамгаалах ажлын хүрээн бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной микробиологийн аргаар тэмцэх ажлын 1 удаа, энгийн механик аргаар тэмцэх ажлыг 1 удаа зохион байгуулж нийт 10000 га талбайд устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн.	90
2.8.1	Жил бүр зохион байгуулагдах “Дундговь Түншлэл” арга хэмжээнд оролцох	ОНТ	Оролцогчдын тоо	1	1	Ковид 19 өвчний улмаас зохион байгуулагдаагүй.	ҮБ-гүй
2.8.2	СХС-ийн зээлийн үр дүн, эргэн төлөлтийг сайжруулах, шаардлага хангасан зээлчдэгдэд зээл олгуулах ажлыг зохион байгуулах	-	Эргэн төлөлтийн хувь ажлын байрны тоо Зээлийн хэмжээ	-	-	Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 4 ААНБ, 23 иргэн байгаагаас нийт 68.2 сая төгрөг төлснөөс үндсэн зээлд 55.5 сая төгрөг, зээлийн хүүд 2,5 сая төгрөг, алдангид 10,2 сая төгрөг төлсөн. Зээлээ бүрэн төлж барагдуулсан 6 зээлдэгч байна. 80 сая төгрөгийн зээлийг эргэн төлүүлэх төлөвлөгөө батлуулснаас 68,2 төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 85,2%-тай хэрэгжсэн байна.	90
2.8.3	Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулна.	УТ 10,0	Талбайн хэмжээ	1	2	Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной микробиологийн болон энгийн механик аргаар тэмцэх ажлыг 2 удаа зохион байгуулж нийт 10,000 га талбайд устгалын ажлыг зохион байгуулсан.	90

2.8.4	Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж иргэдэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	-	Ногоо тариалсан иргэдийн тоо	-	-	Энэ онд төмс, хүнсний ногоо тариалдаг 2 өрх шинээр нэмэгдсэн. Хүнсний ногоо тариалалтыг 2020 онд 200 кг байсныг 2021 онд 300 кг буюу 50%-аар өсгөх, сумын хүн амыг хүнсний ногоогоор хангагдах хангамжийн хувийг 2%-д хүргэх зорилтын хүрээнд өнөөгийн байдлаар нийт хүн амын 1.6% нь сумандаа тариалсан төмс, хүнсний ногоогоор хангагдаад байна.	90
2.9	ХАА-н салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангаж, малын тоог чанарт шилжүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	90	46,2 сая төгрөгийн үнэ бүхий 84,0 тн байгалийн өвс, 11,6 тн үйлдвэрийн тэжээл татан авч сумын аюулгүй нөөцийг бүрдүүлж ажиллалаа. Малчин өрх бүрийг 4тн-оос доошгүй гар тэжээл бэлтгүүлэх, хадлан тэжээл бэлтгэх талаар Засаг даргын албан даалгавар гаргуулан малчдад хүргэж ажилласан. Малчид 194 тн өвс, 5 тн ногоон тэжээл, 75 тн үйлдвэрийн тэжээл, 221 тн гар тэжээл, 63 тн хужир шүү бэлтгэсэн мэдээг хүлээн авч нэгтгэн ХХААГ-т хүргэсэн. “Мал аж ахуйн эдийн засгийг нэмэгдүүлэх” төслийг Дэлгэрэх зам багт 15688 толгой мал ээмэгжүүлэн бүртгэл мэдээлийн санд орууллаа.	90
2.9.1	Бог малын хээлтүүлэгчийг мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж болон хээлтүүлгийн бус үед эх сүргээс ялгах ажил зохион байгуулах	-	Ялган төвлөрүүлсэн хуц, ухны хувь	-	-	1, 2-р багийн хээлтүүлэгчийг 1-р багийн малчин Ч.Чимэддорж, 3, 4-р багийн хээлтүүлэгчийг 4-р багийн малчин Ц.Баатарсүх нартай гэрээ байгуулан эх сүргээс ялган төвлөрүүллээ.	90
2.9.2	Тэмээ өсгөх бодлогыг хэрэгжүүлэх	-	Зохион байгуулсан ажлын тоо	-	-	Сумын хэмжээнд нийт 62 төл хүлээн авсан.	50
2.9.3	Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг ээмэгжүүлэн бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах	-	Ээмэгжүүлж бүртгэлжүүлсэн мал	-	-	Азийн хөгжлийн сан, ХХААХҮЯамтай хамтарсан “Мал аж ахуйн эдийн засгийг нэмэгдүүлэх” төслийг Дэлгэрэх зам багт хэрэгжүүлэн тэмээ-39, үхэр-319, хонь-7642, ямаа-7688 толгой мал буюу бүгд 15688 толгой мал ээмэгжүүлэн бүртгэл мэдээлийн санд орууллаа.	90
2.9.4	Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг зохион байгуулж, ЗГ-ын тогтоолын дагуу сумын өвс, тэжээлийн	ОНТ	Нөөц бүрдүүлсэн байдал, тн	-	-	46,2 сая төгрөгийн үнэ бүхий 84,0 тн байгалийн өвс, 11,6 тн үйлдвэрийн тэжээл татан авч сумын аюулгүй нөөцийг бүрдүүлж ажиллалаа. Малчин өрх бүрийг 4тн-оос доошгүй гар тэжээл бэлтгүүлэх, хадлан тэжээл бэлтгэх	90

	нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.					талаар Засаг даргын албан даалгавар гаргуулан малчдад хүргэж ажилласан. Малчид 194 тн өвс, 5 тн ногоон тэжээл, 75 тн үйлдвэрийн тэжээл, 221 тн гар тэжээл, 63 тн хужир шүү бэлтгэсэн мэдээг хүлээн авч нэгтгэн ХХААГ-т хүргэсэн.	
ЗОРИЛТЫН ДУНДАЖ 90%-18, 70%-1							88,9
АРГА ХЭМЖЭЭНИЙ ДУНДАЖ 90%-61, 70%-14, 50%-3, 30%-1, 0%-1, ҮБ-гүй-3							83,1

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР